



**ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН
ИНДЕКСИЙН СУДАЛГАА
(2012 оны 3-р улирал)**

Товч агуулга

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ)


Хэрэглэгчийн хүлээлтийн индекс нь дэлхийн олонхи хөгжингүй орнуудад тухайн улс өөрийн иргэдийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын ирээдүйн хандлагыг тодорхойлох зорилгоор тооцдог өндөр ач холбогдол бүхий эдийн засгийн индикатор юм. Аливаа нэгэн улсын эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлоход тэргүүлэгч буюу эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг харуулдаг индикатор болон улс орны эдийн засгийн тухайн үеийн төлөвийг харуулдаг индикаторыг тооцож үзэх шаардлагатай болдог. ХХИ нь эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг урьдчилан харуулдаг тэргүүлэгч индикатор бөгөөд зах зээлийн эдийн засагтай орнуудын хувьд тухайн улсын эдийн засгийн ирээдүйн хандлага нь эдийн засаг дахь хэрэглэгчдийн үйл хөдлөл, эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаархи хүлээлт, тэдгээрийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын хэмжээ зэргээс голчлон хамаардаг болсон учраас дэлхийн олон улс орон хэрэглэгчдийнхээ үйл хөдлөл, хүлээлт дээр тулгуурласан энэ индексийг тооцож, шийдвэр гаргалтандаа чухал үзүүлэлт болгон ашигласаар ирсэн байна.

ХХИ нь зөвхөн бодлого боловсруулагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хувьд бус бизнес эрхлэгчдийн хувьд ч ирээдүйн төлөвлөлт шийдвэр гаргалтандаа ашиглаж болох мэдээллийн чухал эх үүсвэр болдогоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Ийм учраас дэлхийн хөгжингүй орнуудад энэ индекст ихээхэн ач холбогдол өгч тогтмол тооцоор ирсэн. Тухайлбал, Америкийн Conference Board, Германы ZEW зэрэг байгууллагууд энэ индексийг тогтмол тооцдог бөгөөд индекс нь эдийн засгийн ирээдүйн чиг хандлагыг гайхалтай зөв харуулж чаддаг нь батлагдсан байна.

Манай улсын хувьд анх 2009 оноос эхлэн Санхүүгийн Зах Зээлийн Холбоо болон Нээлттэй Нийгэм Форум уг индексийг Улаанбаатар хотын хэмжээнд тус тусдаа тооцож байсан бөгөөд 2010 оны нэгдүгээр улирлаас эхлэн 2 байгууллага хамтран энэхүү индексийг тооцож байна.

График 1. ХХИ ба Монголын эдийн засгийн өсөлтийн хамаарал



Дээрх графикт ХХИ ба Монгол улсын эдийн засгийн өсөлт хамаарал өндөртэй байгааг харуулжээ. ХХИ нь өөрөө яг 1 жилийн дараах байдлыг илэрхийлдэг түрүүлэгч индикаторынхаа хувьд 2013 оны 3-р улирал хүртэлх таамаглалыг бий болгож байна.

Монголын хэрэглэгчийн хүлээлтийн индексийг тооцох аргачлал

ХХИ-ийг Монгол улсын эдийн засгийн бүтцэд тохируулан улирал тутамд нэг удаа, нийт 1000 хүнээс санал асуулга авах замаар тооцож байна. Санал асуулгад оролцогчийг Монгол улсын нийгэм, эдийн засгийн бүтцийг төлөөлөхүйц байдлаар статистик түүврийн аргаар сонгодог. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн санал асуулга нь өөртөө Хэрэглэгчийн хүлээлтийн индекс болон индикаторыг агуулдаг. Индекс нь хэрэглэгчдийн хүлээлт өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг бол индикатор нь хэрэглэгчдийн эдийн засгийн талаарх ерөнхий хүлээлт эерэг эсвэл сөрөг байгаа эсэхийг харуулдаг ач холбогдолтой юм. Санал асуулга нь индекс болон индикаторыг тооцоолоход ашиглагдах таван асуулт мөн эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаархи хүлээлтийг тодруулах зорилго бүхий 14 нэмэлт асуултаас бүрддэг. Асуултууд нь одоогийн нөхцөл байдал ба ирээдүйн хүлээлт гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Түүнчлэн ХХИ нь:

- а. Хэрэглэгчдийн хэрэглээний хандлагад гарч байгаа өөрчлөлт, хүлээлт
- б. Инфляци
- в. Ажилгүйдэл
- г. Банкны секторын талаарх хэрэглэгчдийн байр суурь
- д. Тухайн үеийн эдийн засаг, бизнесийн онцлог үйл явдал

гэсэн үндсэн 5 чиглэлээр хэрэглэгчид ирээдүйд ямар хүлээлттэй байгааг тодруулах зорилготой.

Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн судалгааг санамсаргүй түүврийн аргаар доорх эдийн засгийн 14 салбарын нийт 1000 хүнээс асуулга авч тооцдог.

- ХАА, ан агнуур, ойн аж ахуй
- Уул уурхай, олборлох үйлдвэр
- Боловсруулах үйлдвэр
- Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж
- Барилга
- Бөөний болон жижиглэн худалдаа
- Зочид буудал, зоогийн газар, ресторан
- Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй
- Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа
- Үл хөдлөх хөрөнгө, түрээс
- Төр, батлан хамгаалах
- Боловсрол
- Эрүүл мэнд, нийгмийн халамж
- Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ


2012 оны 2 дугаар улирлын ХХИ-ийн судалгааны санал асуулгыг нийт 4 бүлэг, 16 асуулттайгаар авсан.

- А хэсэг оролцогчдын ерөнхий мэдээлэл авах зорилготой бөгөөд 6 дэд асуултаас бүрдэнэ.

- Б хэсэг нь хэрэглэгчдийн ирээдүйн хандлагыг тодорхойлох зорилготой, 8 асуултаас бүрдсэн. Тус хэсгийн асуултууд, хариулт сонголтыг олон улсад хийгддэг хэрэглэгчийн хүлээлийн талаарх түүвэр судалгаануудад өргөн хэрэглэгддэг стандарт асуултуудаас сонгон авсан болно.
- В хэсгийн асуулт хэрэглэгчдийн банк санхүүгийн байгууллагад итгэх итгэлцүүрийг тодорхойлох зорилготой нийт 6 асуулттай.
- Харин сүүлийн Г хэсэг нь тухайн цаг үед гарч байгаа онцлог үйл явдлуудын талаар хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлох зорилго бүхий доорхи 2 нээлттэй асуултаас бүрдсэн. Тэдгээр асуултууд нь:
 1. Дараах үзүүлэлт болон хүчин зүйлүүдийг даатгалын бүтээгдэхүүн худалдан авах үед таны хувьд ач холбогдолтой байдлаар нь дугаарлана уу?
 - a. Даатгалын үнэ
 - b. Даатгалын хамаарч буй эрсдэл
 - c. Даатгалын компанийн нэр хүнд
 - d. Даатгалын компанийн таньд хүрч үйлчлэх байдал
 - e. Заавал даатгалын хууль
 2. Дараах мэдээллийн сувгуудыг таны худалдан авах шийдвэрт нөлөөлдөг байдлаар нь дугаарлана уу?
 - a. Зам дагуу байрлах самбар
 - b. ФМ Радио
 - c. Интернет
 - d. Өдөр тутмын сонин
 - e. Ойр дотны хүмүүс найз нөхдийн зөвлөгөө

Хэрэглэгчийн Хүлээлтийн Индекс 2012 оны 3-р улирал /Ерөнхий үр дүн/**Хэрэглэгчдийн ирээдүйн талаарх эерэг хүлээлт дахин буурч эхэллээ.**

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс өмнөх 2 улирал дарааллан өссөн боловч энэ улиралд өмнөх улирлаас 9 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 20-н нэгж хувиар тус тус буурч 184 болсон байна. Энэ нь иргэдийн эдийн засгийн талаарх хүлээлт эргэн буурч байна хэмээн үзэж болох ч улирлын тодорхой нөлөөлөл байж болох юм.

График 2. Хэрэглэгчийн хүлээлтийн индекс

Монголын эдийн засгийн өсөлт 2011 оны эцсээр 17,3% байсан боловч энэ оны 3-р улирлын байдлаар 12,5% болж буурсан билээ. Энэ нь цаашлаад Хятадын эдийн засгийн уналттай холбоотой байж болох юм.

Хэрэглэгчдийн өнөөгийн нөхцөл байдлын индикатор болон ирээдүйн нөхцөл байдлын индикатор өмнөх улиралтай харьцуулахад буурсан дүнтэй гарчээ. Сүүлийн 3-н улирлын хугацаанд ирээдүйн нөхцөл байдлын индикатор тогтвортой байсан боловч энэ улиралд харьцангуй өндөр хувиар буулаа.


- Өнөөгийн нөхцөл байдлын индикатор – 51,675
- Ирээдүйн нөхцөл байдлын индикатор – 65,733

Өнөөгийн нөхцөл байдлын индикатор нь хэрэглэгчид өөрийн болоод улс орны эдийн засгийн өнөөгийн төлөвийн талаар ямар бодолтой байгааг харуулдаг бол ирээдүйн төлөв байдлын индикатор нь хэрэглэгчид эдийн засгийн ирээдүйн хандлагын талаар ямар хүлээлттэй байгааг харуулдаг. Уг индикаторууд 50-иас дээш байвал одоогийн болоод ирээдүйн эдийн засгийн байдал сайн (эерэг) байгааг харуулах бол 50-иас доош байвал дээрхийн эсрэг утгыг агуулна.

Хэрэглэгчийн Хүлээлтийн Индекс 2012 оны 3 дугаар улирал /Дэлгэрэнгүй үр дүн/

Хэсэг А


График 4. Судалгаанд оролцогчдын насны бүтэц



Нийт судалгаанд оролцогчдын 18-29 насны иргэд 44%, 30-49 насны иргэд 43% байгаа нь өмнөх улирлуудтай ойролцоо буюу манай судалгаа нь нийт иргэдийн насны харьцааг хадгалж байна.

Судалгаанд 1000 гаруй хүн оролцсон ба 700 орчим нь дээд боловсролтой буюу эдийн засгийн талаар тодорхой ойлголт бүхий хүмүүс хамрагдсан нь судалгааны үр дүнг чанаржуулж байна.


График 5. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал



Мөн орлогын хувьд дийлэнх хувийг 300-500 мянга, 500-800 мянган төгрөг бүхий орлоготой хүмүүс эзэлж байна. Энэ судалгааг дундаж орлоготой хүмүүс рүү чиглэн авсантай холбоотой юм.


Хэсэг Б

График 6. Бараа бүтээгдэхүүний үнэ сүүлийн 1 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Инфляцийн түвшин улсын хэмжээнд 14,8 байгаа тул судалдгаанд оролцогч иргэдийн 87% нь үнэ өссөн гэж хариулах нь аргаггүй юм. Энэ нь цаашид ч өссөөр байх болно гэдгийг хүмүүсийн хандлага хэлж буй хэрэг.


График 7. Та ажлын байраа ойрын нэг жилийн хугацаанд солих бодолтой байна уу?



Ажил эрхлэлтийн байдал улам бүр тогтворжиж байна. Өмнөх улиралд 31% нь ажлаа солих бодолтой байсан бол энэ улиралд ердөө 18% нь ажлаа солих бодолтой байгаа аж.

Хэсэг В

График 8. Өнөөгийн нөхцөлд хүмүүс мөнгөн хөрөнгөө хэрхэн байршуулбал зохистой вэ?



Хуримтлал, илүүдэл орлогоо хаана байршуулбал зохистой вэ гэх асуултад хамгийн их нь буюу 28% нь орон сууц гэж хариулсан хэдий ч энэ нь өмнөх улирлаас буурсан үзүүлэлт юм. Учир нь байрны үнэ дээд цэгтээ хүрээд байна хэмээн үзсэнтэй холбоотой. Харин Банкны валютын хадгаламжийг сонирхсон хүний тоо эрс нэмэгдээд буй юм. Энэ талаар Санхүү эдийн засгийн багш Б.Мөнхзаяа/МВА, докторант/ ийнхүү дүгнэлээ:

“Валютын хадгаламжийг иргэд сонирхох нь эдийн засгийн хямралын үед тохиолддог нэг үзэгдэл, 2008 оны хямралаар яг ийм зүйл болж байсан. Цаашлаад энэ нь иргэд өөрсдийн мөнгийг инфляциас хамгаалах арга болж өгдөг.”

График 9. Монголын банкуудыг хэр найдвартай гэж бодож байна вэ?



“2012 оны 2-р улирлаас эхлэн Монголын арилжааны банкуудын зарим нэг үзүүлэлт унаж эхэлсэн. Гэвч энэ нь банкны сектор уналтанд орлоо гэсэн үг биш. Иймд хамгийн оновчтой хариулт нь мэдэхгүй гэдэг болоод буй юм.” хэмээн дүгнэжээ.

Хэсэг Г (нэмэлт асуулт)

График 10. Даатгалын бүтээгдэхүүн худалдан авах үед хамгийн их ач холбогдолтой хүчин зүйл



Жолоочийн албан журмын даатгал хийлгэх болсонтой холбоотойгоор иргэд даатгалын үйлчилгээг өргөнөөр хэрэглэх болсон. Харин бүтээгдэхүүний сонголтыг хийхэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл нь Даатгалын компанийн танд хүрж үйлчлэх байдал 27% байгаа юм. Үүний дараагаар Даатгалын үнэ 22%, Заавал даатгалын хууль 19% байна.

Тус асуултын 23% нь интернет гэж хариулсан нь Social media сайтуудыг хэрэглэгчид өргөнөөр хэрэглэдэг болсонтой холбоотой. Мөн 20% нь найз нөхдийн зөвлөгөө, 22% ФМ Радио, 17% нь сонин хэмээн хариулжээ.

График 11. Мэдээллийн сувгуудын шийдвэрт нөлөөлдөг байдал

